

## ТАНИЛЦУУЛГА

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулиудыг боловсронгуй болгох зорилгоор боловсруулсан холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн талаар

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанаар Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй шийдвэрт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн үр дүнгийн тайлан, хуулиар тусгайллан эрх олгосон заалтын судалгааны дүн, цаашид авах арга хэмжээний тухай хэлэлцээд, Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллагад тус тус эрх олгогдсон заалтыг 2 дахин багасгах чиглэлийг баримтлан холбогдох хуулийн төсөл боловсруулж, танилцуулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” 191 дүгээр захирамжаар байгуулагдсан. Уг захирамжийг хэрэгжүүлэх зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн сайдыг 2024 оны А/03 дугаар тушаалаар Хууль зүй, дотоод хэргийн салбарын хууль тогтоомж, дүрэм журамд хяналт шинжилгээ хийж, холбогдох хуулийн төсөл боловсруулах Ажлын дэд хэсэг байгуулагдан ажиллав.

Дэд Ажлын хэсэг нь Хууль зүй, дотоод хэргийн салбарт хамаарах 35 хууль тогтоомжоор эрх олгосон 160 гаруй заалт, түүний дагуу баталсан дүрэм, журамтай нэг бүрчлэн танилцаж хяналт шинжилгээ, үнэлгээ хийсний үндсэн дээр хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах багцын хүрээнд 26 хуульд 65 журмыг холбогдох хуулиар зохицуулагдах ёстай гэж үзэн хуулийн төслүүдийг боловсрууллаа. Эдгээрээс Галт зэвсгийн тухай хууль нь олон тооны журмын зохицуулалтыг хуульд тусгах шаардлагатай байгаагаас нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлбэрээр бичих боломжгүй болсон тул хуулийн шинэчилсэн найруулга хэлбэрээр төслийг боловсруулав. Дээрх хуулийн төсөлд Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу үзэл баримтлалыг тусад нь тодорхойлж, холбогдох үнэлгээ, судалгааг хийж ажиллав.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Хууль зүйн туслалцааны тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай, Гэрч хохирогчийг хамгаалах тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай зэрэг 7 хуульд 25 эрх олгосон заалтын дагуу баталсан журмыг нэмж тусгах хуулийн төслүүдийг Хүний эрхийг хангах багц хуулийн төслүүдийн хүрээнд боловсруулж байгаа болно. Ингэснээр Хууль зүй, дотоод хэргийн салбарт Засгийн газрын 2023 оны 48 дугаар тэмдэглэлээр өгсөн захиргааны хэм хэмжээний актыг хоёр дахин бууруулах чиглэлд 90 журмаар зохицуулж байгаа харилцааг хуульд тусгахаар төсөл боловсруулаад байна.

Хуулийн төслүүдийн талаарх товч танилцуулга болон дэлгэрэнгүй танилцуулга бэлтгэсэн болно.

### **1.Харьяатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Засгийн газрын 2023 оны 62 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан гадаадын иргэн, харьяалалгүй хүнд тавих шалгуурыг тогтоох журам”-аар зохицуулж байсан шалгуур болон харьяат болох хүсэлт

гаргагчийн бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг журмаар батлахаар байгааг Харьяатын тухай хуульд тусгах хүрээнд эрх олгосон 2 заалтыг хүчингүй болгож хуулийн төслийг боловсрууллаа.

## **2.Оюуны өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Монгол Улсын Их Хурлаас Оюуны өмчийн тухай хуулийг 2020 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр баталж, 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж байна. Оюуны өмчийн хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны хэм хэмжээний актад дүн шинжилгээ хийж, дараах 6 журмыг Оюуны өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх боломжтой гэж үзэж хуулийн төслийг боловсруулсан. Үүнд:

Оюуны өмчийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт “Монгол Улсын Ерөнхий сайдын дэргэд Оюуны өмчийн үндэсний зөвлөл ажиллана”, гэж мөн зүйлийн 10.3 дахь хэсэг “Оюуны өмчийн үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Засгийн газар батална.” гэж тус тус заасны дагуу Засгийн газрын 2021 оны 71 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар Оюуны өмчийн үндэсний зөвлөлийн ажиллах журмын баталсан. Зөвлөлийн ажиллах журам нь бүтцийн хувьд нийтлэг үндэслэл, Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажлын зохион байгуулалт, Зөвлөлийн бүрэн эрх гэсэн гурван хэсгээс бүрдсэн бөгөөд уг харилцааг Оюуны өмчийн тухай хуулийн 10 дугаар зүйлийг өөрчлөн найруулах хэлбэрээр хуульд тусгахаар боловсрууллаа.

Оюуны өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалтад “Оюуны өмчийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн нь оюуны өмчийн шилдэг бүтээл шалгаруулах журмыг батална” гэж заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/234 тушаалын нэгдүгээр хавсралтаар “Оюуны өмчийн шилдэг бүтээл шалгаруулах журмыг, хоёрдугаар хавсралтаар “Шилдэг бүтээлд нэр дэвшигэлэхэд бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт”-ыг баталсан. Тус харилцааг Оюуны өмчийн тухай хуульд тусгаснаар оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулахад дэмжлэг үзүүлж, оюуны өмчийн байгууллагын үйл ажиллагааны зорилго, төрөөс хэрэгжүүлж байгаа бодлого болон үзүүлэх дэмжлэг илүү тодорхой болж улмаар нийгэм, эдийн засаг, шинжлэх ухааны хөгжил, байгаль орчин, хүний амьдралын чанарт үзүүлсэн нөлөө, экспорт, дотоодын борлуулалтын цэвэр ашиг болон олон улсын түвшинд Монгол хүний бүтээсэн оюуны өмч үнэлэгдэх нөхцөл бүрдэх юм.

Оюуны өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтад “хамтын удирдлагын байгууллагын үйл ажиллагаанд баримтлах журмыг Оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/17 дугаар тушаалаар нэгдүгээр хавсралтаар “Хамтын удирдлагын байгууллагын үйл ажиллагаанд баримтлах журам”-ыг, хоёрдугаар хавсралтаар “Хамтын удирдлагын байгууллагатай хамтран ажиллах гэрээ”-ний загварыг баталсан. Оюуны өмчийн тухай хуулийг 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр баталж, 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн бөгөөд дээрх журмаар зохицуулагдаж буй харилцаа 2021 оны 05 дугаар сарын 06-ны өдөр батлагдсан Зохиогчийн эрхийн тухай хуулийн 47, 48, 49, 50 дугаар зүйлээр зохицуулагдсан болно. Иймд тус журмаар зохицуулагдаж буй харилцаа нь хуульчлах нь зүйтэй гэж үзэж хуулийн төслийг боловсрууллаа.

Оюуны өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Оюуны өмчийн зуучлалыг оюуны өмчийн байгууллагад бүртгэгдсэн хуулийн этгээд эрхэлнэ.” гэж, мөн зүйлийн 18.2 дахь хэсэгт “Оюуны өмчийн зуучлагчид тавигдах шаардлага, оюуны өмчийн байгууллагад бүртгүүлэх журмыг оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэж, мөн зүйлийн 18.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 18.1-д заасан хуулийн этгээдтэй оюуны өмчийн байгууллага гэрээ

байгуулна. Гэрээний загварыг оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална." гэж тус тус заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/18 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар "Оюуны өмчийн зуучлагчийг бүртгэх журам", хоёрдугаар хавсралтаар "Оюуны өмчийн зуучлагчтай хамтран ажиллах гэрээний загвар"-ыг баталж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Оюуны өмчийн тухай хуулийн Гуравдугаар бүлэгт оюуны өмчийн эрхийг хамгаалах талаар иргэн, хуулийн этгээдийн оролцоог хуульчилсан бөгөөд мөн хуулийн 18 дугаар зүйлд оюуны өмчийн зуучлалын үйл ажиллагааг зохицуулсан тул Оюуны өмчийн зуучлагчийг бүртгэх журмыг тус хуулийн заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах замаар хуульд тусгах боломжтой гэж үзэж, хуулийн төслийг боловсрууллаа.

Оюуны өмчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалтад Оюуны өмчийн байгууллагын чиг үүрэг нь "оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллах этгээдийг шалгаруулах, тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох", мөн зүйлийн 12.1.14 дэх заалтад "оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн ажиллах журам батлах" гэж заасны дагуу Оюуны өмчийн газрын даргын 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/08 дугаар тушаалаар "Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийг сонгон шалгаруулах, тэдгээрийн үйл ажиллагаанд баримтлах журам"-ыг баталж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Оюуны өмчийн тухай хуулийн Гуравдугаар бүлэгт оюуны өмчийн эрхийг хамгаалах талаар иргэн, хуулийн этгээдийн оролцоог хуульчилсан бөгөөд 16 дугаар зүйлд оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн үйл ажиллагааг зохицуулсан тул "Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийг сонгон шалгаруулах, тэдгээрийн үйл ажиллагаанд баримтлах журам"-ыг тус заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах замаар хуульд тусгах боломжтой гэж үзэж, хуулийн төслийг боловсрууллаа.

### **3.Зохиогчийн эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 5 дугаар сарын 06-ны өдөр шинэчлэн баталсан Зохиогчийн эрхийн тухай хуулийн 35 дугаар зүйлд зохиогч, зохиогчийн эрхийн эзэмшигч нь тодорхойгүй бүтээлийг ашиглах тохиолдолд оюуны өмчийн байгууллагаас бүтээл ашиглах зөвшөөрөл олгох, зохиогч, зохиогчийн эрх эзэмшигч тодорхой болсон бол тэдгээрт уг бүтээлийг төлбөртэй ашиглуулсны орлогын зохих хувийг нөхөн олгох зохицуулалт тусгагдсан бөгөөд мөн хуулийн 35.4 дэх заалтад бүтээл ашигласан төлбөрийг нөхөж олгох журмыг Засгийн газар батална гэж заасны дагуу Засгийн газрын 2022 оны 405 дугаар тогтоолоор тус журмыг батлуулан, мөрдөн ажиллаж байна. Зохиогчийн эрхийн тухай хуулийн 35 дугаар зүйлд Зохиогчийн эрхийн бүтээл ашиглах харилцааг тусгайллан хуульчилсан тул тус заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах замаар журмаар зохицуулагдаж буй харилцааг хуульд тусгах боломжтой гэж үзлээ.

### **4.Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтад "барааны тэмдэг, газар зүйн заалтын мэдүүлэг гаргах, шүүлт хийх, тэдгээрийг бүртгэх, улсын бүртгэл хөтлөх, тэдгээрт өөрчлөлт оруулах, барааны тэмдгийг нийтэд түгээмэл болсонд тооцох, газар зүйн заалтыг бүртгэгдсэнийг илэрхийлэх таних тэмдгийг хэрэглэхтэй холбоотой журам, дүрмийг боловсруулж, батлах;" чиг үүргийг Оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ гэж заасны дагуу Оюуны өмчийн газрын даргын 2021 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн А/122 дугаар тушаалаар Барааны тэмдэг, газар зүйн заалтын мэдүүлэг гаргах, шүүлт хийх, тэдгээрийг бүртгэх, улсын бүртгэл хөтлөх, тэдгээрт өөрчлөлт оруулах журмыг баталсан.

Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэгт заасан “Энэ хуулийн 5.1.5, 5.2.2-т заасан Монгол Улсын түүхэн, нэрд гарсан хүмүүсийг тодорхойлох болон барааны тэмдгийн мэдүүлэг гаргах, шүүлт хийх журмыг оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага /цаашид “төрийн захиргааны байгууллага” гэх/ баталж мөрдүүлнэ.” гэж заасан харилцаа Оюуны өмчийн газрын даргын 2021 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн А/122 дугаар тушаалаар батлагдсан Барааны тэмдэг, газар зүйн заалтын мэдүүлэг гаргах, шүүлт хийх, тэдгээрийг бүртгэх, улсын бүртгэл хөтлөх, тэдгээрт өөрчлөлт оруулах журмаар зохицуулагдаг харилцаа тул Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т өөрчлөлт оруулах замаар тухайн харилцааг Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтад заасан Барааны тэмдэг, газар зүйн заалтын мэдүүлэг гаргах, шүүлт хийх, тэдгээрийг бүртгэх, улсын бүртгэл хөтлөх, тэдгээрт өөрчлөлт оруулах нийтлэг журмаар шийдвэрлэх боломжтой гэж үзэж хуулийн төслийг боловсрууллаа.

#### **5.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт “Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 8.3-т заасан шалгуурыг хангасан архивын баримтыг хосгүй үнэт баримтад хамруулна.” гэж заасан боловч Соёлын өвийг хамгаалах тухай хуульд 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөлт орж, 8.3 дахь хэсгийг хүчингүй болгосон болно. Энэ нь хууль хоорондын уялдаа алдагдан хийдэл үүсээд байгаа бөгөөд “архивын хосгүй үнэт баримт”-д юу хамаарахыг тодорхойлох боломжгүй нөхцөл үүсээд байгаа болно. Иймд хуулийн энэхүү хийдлийг арилгах зорилгоор Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд архивын хосгүй үнэт баримтыг тодорхойлох шалгуур үзүүлэлтийг тусгана. Мөн хуулийн 28 дугаар зүйлийн 28.7 дахь хэсэгт “Энэ хуулийн 28.6-д заасан гэрээний загвар, гэрээ байгуулах журмыг архив, албан хэрэг хөтлөлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.” гэж Төрийн бус байгууллага, улс төрийн нам, шашны байгууллага, хувийн эзэмшлийн хуулийн этгээд, хувь хүний архивын баримтыг төрийн архивд гэрээний үндсэн дээр шилжүүлэн хадгалуулахад баримтлах журмыг батлах эрх олгосон нь мөн хуулийн 15.1.6 дахь заалтад заасан Төрийн архивын журмаар зохицуулах боломжтой буюу давхардал үүссэн тул эрх олгосон заалтыг хүчингүй болгохоор төсөлд тусгана.

Түүнчлэн Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4 дэх хэсэгт “Архивын баримтыг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах нийтлэг журам, архиваас үзүүлэх үйлчилгээний хөлсний хэмжээг архив, албан хэрэг хөтлөлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.” гэж мөн эрх олгосон заалт тусгасан нь шаардлагагүй буюу Төрийн архивын дүрэмд тусгагдсан байдаг тул уг эрх олгосон заалтыг хүчингүй болгоно.

#### **6.Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт “Иргэний үнэмлэхийн загвар, тодорхойлолт болон дүрмийг Засгийн газар батална.” гэж заасны дагуу 2018 оны 396 дугаар Засгийн газрын тогтоолоор иргэний үнэмлэхийн загвар, тодорхойлолт, дүрмийг баталсан бөгөөд үүргээр зохицуулж буй харилцаа агуулгын хувьд Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 16 дугаар зүйлтэй давхцаж байх тул энэ хэсгийг хүчингүй болгох, Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөн оруулан тусдаа дүрэм гэж байхгүйгээр иргэний үнэмлэхийн загвар, тодорхойлолтыг батлахаар өөрчлөх.

Мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.8 дахь хэсэгт “Энэ хуулийн 12.2 буюу Улсын бүртгэлийн нэгдмэл сангийн нээлттэй мэдээллийн хэсэг, 12.6-д заасан буюу

тухайн иргэн, хуулийн этгээдийн зөвшөөрлөөр, эсхүл хязгаарлалттайгаар буюу нотариатчаар дамжуулан хуульд заасан зорилгоор, хуульд заасан үндэслэл, журмын дагуу өгөх мэдээллээс лавлагаа авах, мэдээлэл өгөх, энэ хуулийн 12.3-т заасан мэдээлэл буюу хаалттай мэдээлэлтэй танилцах, мэдээлэл өгөх журмыг Засгийн газар батална.” гэж заасан болно. Уг мэдээлэл өгөх, хаалттай мэдээлэлтэй танилцах талаарх харилцааг Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 12 дугаар зүйл, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлд тодорхой тусгасан бөгөөд эрх олгосон заалтын дагуу баталсан Засгийн газрын тогтоолын 1, 2 дугаар хавсралтаар батлагдсан журмаар зохицуулж байгаа нээлттэй, хязгаарлалттай, хаалттай мэдээлэл өгөх, танилцах тухай заалт нь агуулгын хувьд дээрх хуулиудтай давхцаж байх тул эрх олгосон заалтыг хүчингүй болгох, давхардаагүй зохицуулалтыг хуульд тусгана.

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6 дахь хэсэгт “Улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд мэдээлэл хүлээн авах, хадгалах, түүний аюулгүй байдлыг хангах журмыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэж заасны дагуу “Улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд мэдээлэл хүлээн авах, хадгалах, түүний аюулгүй байдлыг хангах журам”-ыг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны А/02 дугаар тушаалаар баталсан бөгөөд журам нь ерөнхий зохицуулалтыг тусгасан, хуулийн 11 дүгээр зүйлтэй давхцаж байгаа тул эрх олгосон заалтыг хүчингүй болгохоор хуульд тусгана.

#### **7.Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.8 дахь хэсэгт “Иргэний улсын бүртгэл хөтлөх журам болон иргэний төрсний, гэрлэсний, нас барсны улсын бүртгэлийн гэрчилгээний загварыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэж зааснаас иргэний бүртгэл хөтлөх журмыг хуульд тусгах нь зүйтэй гэж үзэж хуулийн төсөл боловсруулна.

Мөн Монгол Улсын иргэнд Регистрийн дугаар шинээр олгох, түүнийг өөрчлөх, иргэний улсын бүртгэлийн эх нотлох баримтыг бүрдүүлэх, хүргүүлэх харилцаа давхардсан, тодруулах зарим зохицуулалтыг хуульд тусгахаар төслийг боловсруулав. Ингэснээр эрх олгосон заалтын дагуу баталсан 4 журмыг хуульд тусгаж байна.

#### **8.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт “Улсын бүртгэлийн байгууллага гадаадын хуулийн этгээд /компани, нөхөрлөл/-ийн төлөөлөгчийн газрыг бүртгэх бөгөөд холбогдох журмыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”, гэж мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэгт “Хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрыг улсын бүртгэлд хөтлөх журмыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэж тус тус заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018.11.01-ний өдрийн А/208 тоот тушаалаар батлагдсан. Хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрын улсын бүртгэл хөтлөх журам батлагдсан. Уг журам нь 13 зүйл, 70 хэсэг, 133 заалттайгаас 8 зүйл, 9 хэсэг, 2 заалт Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, 1 хэсэг 3 заалт Улсын бүртгэлийн ерөнхий хууль, 2 зүйл Иргэний хууль, 1 зүйл Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн холбогдох зүйл заалтуудтай утга санаа давхардсан тул эрх олгосон заалтыг хүчингүй болгож, холбогдох зохицуулалтыг хуульд тусгана.

Мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсэгт “Хуулийн этгээдийн нэр баталгаажуулах талаар иргэн, хуулийн этгээд хүсэлт гаргах, түүнд тавигдах шаардлага, хязгаарлалт, нэр баталгаажуулахтай холбогдсон журмыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн

газар батална.” Гэсний дагуу хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалт хийх асуудал журмаар зохицуулагдаж байгаа бөгөөд энэ нь хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой үндсэн харилцаа, мөн талууд маргах боломжтой, Иргэний хууль болон бусад хуультай давхцалтай зохицуулалттай тул эрх олгосон заалтыг хүчингүй болгож, хуульд холбогдох зохицуулалтыг тусгана.

Мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.11 дэх хэсэгт “Тамга, тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих, лавлагаа олгох журмыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэж заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018.11.19-ний өдрийн А/216 дугаар тушаалаар журмыг баталсан. Уг журам нь 10 зүйл, 36 хэсэг, 50 заалттайгаас 4 хэсэг, 6 заалт Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуультай давхардсан, 5 хэсэг Засгийн Газрын 2021 оны 226 тогтоолоор батлагдсан “Тамга, тэмдэг баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам”-тай тус тус давхардсан тул тусдаа журам байх шаардлагагүй тул холбогдох зохицуулалтыг хуульд болон журамд нэгтгэн тусгах шаардлагатай.

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Гадаад харилцааны сайдын 2019.01.24-ний өдрийн А/16, А/07 дугаар хамтарсан тушаалаар Улсын бүртгэлийн байгууллага олон улсын гэрээ, хэлэлцээрээр байгуулагдсан Засгийн газар хоорондын байгууллага, түүний төлөөлөгчийн газрыг бүртгэж байгаа бөгөөд уг журам нь 2 хэсэг, 12 заалттайгаас Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуультай, 1 хэсэг нь Улсын бүртгэлийн ерөнхий хуультай давхардсан бөгөөд уг харилцааг хуулиар зохицуулах шаардлагатай тул эрх олгосон заалтыг хүчингүй болгохоор төсөл боловсруулна.

Хуулийн этгээдийн хувийн хэрэг хөтлөх харилцааг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын баталсан журмаар зохицуулж байгааг хуульд тусгана.

#### **9.Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дэх хэсэгт “Хуульд өөрөөр заагаагүй бол хөдлөх эд хөрөнгө болон түүнтэй холбоотой эрхийг эрхийн улсын бүртгэлд бүртгүүлж болох бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батална.” гэж заасны дагуу Засгийн газрын 2018.12.26-ны өдрийн 397 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан бөгөөд уг журам нь Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх журмын 1.3 болон 19.1, 19.2, 19.3 дахь заалтаар зохицуулагдсан тул тусгайлан журам байх шаардлагагүй тул үлдэх бусад хэсгийг хуульд тусгана.

#### **10.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлд Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээг үнэлүүлж, үйл ажиллагаанд нь дүгнэлт хөндлөнгийн хуулийн этгээдэд тавих шаардлага, түүнийг сонгон шалгаруулах журмыг Зөвлөл батлахаар эрх олгосныг хүчингүй болгож Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “Улс, орон нутгийн төсөв болон захиалагчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө.” гэсэнд нийцүүлж уг хуулийг дагаж мөрдөхөөр өөрчлөлт орууллаа.

32 дугаар зүйлд зааснаар хэвлэл мэдээллийн байгууллага гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоохтой холбогдсон хойшлуулшгүй мэдээллийг эрх бүхий байгууллагын хүсэлтээр үнэ төлбөргүйгээр яаралтай нийтэлж, нэвтрүүлэх үүрэгтэй бөгөөд энэхүү хойшлуулшгүй мэдээллийг үнэ төлбөргүй яаралтай нийтэлж, нэвтрүүлэх журмыг хууль зүйн болон харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамtran батлахаар заасныг хүчингүй болгож, журмаар бус хуульд нь зохицуулалтыг тусгав.

Мөн хуулийн 32 дугаар зүйлийн 32.10 дахь хэсгээр хэвлэл мэдээллийн байгууллага нь цагдаагийн байгууллагаас ирүүлсэн бага насын хүүхэд сураггүй алга болсон, олдсон тухай хойшлуулшгүй мэдээллийг харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч этгээд үнэ төлбөргүй, нийтэд мэдээлэх үүрэгтэй бөгөөд хэрхэн нийтлэх талаар журам батлахаар заасан нь хэрэгцээ шаардлагагүй байх тул хуульд нь холбогдох зохицуулалтыг тусган журам батлах эрхийг хүчингүй болгож байна.

Мөн хуулийн 34 дүгээр зүйлд зааснаар Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцон тодорхой ажил зохиож, үр дунд хурсэн хүн, хуулийн этгээд урамшуулах болон иргэний өгсөн мэдээллийн дагуу зөрчилд торгох шийтгэл оногдуулсан бол торгох шийтгэлийн дүнгийн 10-20 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг тухайн мэдээлэл өгсөн иргэнд олгож болохоор зохицуулалттай бөгөөд 34 дүгээр зүйлийн 34.3 дахь хэсгээр дээрх урамшуулах хэлбэр, журмыг тогтоох эрхийг олгосон байгааг өөрчилж уг харилцааг зохицуулсан зохицуулалтыг хуульд тусгахаар төсөл боловсруулав.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 37 дугаар зүйлд Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа олон нийтийн хяналт доор явагдах бөгөөд нээлттэй, ил тод байх, ийнхүү ил тод байгаа эсэхэд төрийн хяналт шалгалт хийх эрхгүй байх бөгөөд хяналтыг хэрэгжүүлэхдээ байгууллага, албан тушаалтны эрх хэмжээний асуудлаар шийдвэр гаргах болон байгууллагын дотоод үйл ажиллагаанд оролцохгүй олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэгч байх талаар зааж, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журмыг Засгийн газар батлахаар заасан нь холбогдох бусад хуулиар зохицуулагдсан тул эрх олгосон заалтыг хүчингүй болгохоор төсөл боловсруулаа.

#### **11. Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Цагдаагийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлд цагдаагийн байгууллага иргэдээс мэдээллийг төлбөртэй авах талаар зохицуулсан бөгөөд 39.3 дахь хэсэг мэдээллийн төлбөрийн үнэлгээний жишигийг дотоод хэргийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батлахаар заасан байна. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд 35 дугаар зүйл нь Гэмт хэрэг, зөрчил үйлдэхээр бэлтгэж байгаа болон үйлдсэн тухай мэдээллийг гэмт хэрэг, зөрчлийг хянан шалгах эрх бүхий байгууллага иргэдээс төлбөртэй авах талаарх ерөнхий зохицуулалтыг тусгасан, уг харилцааны тухайд суурь хууль юм. Иргэд байгууллагаас гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээллийг төлбөртэй авах талаар Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.2 дугаар зүйл, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 30.5 дугаар зүйл, Цагдаагийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлд тус тус зохицуулсан байна. Үүнээс Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд зөрчлийн талаарх төлбөртэй мэдээллийн жишиг үнэлгээ, Цагдаагийн албаны тухай хуульд цагдаагийн байгууллагаас зарлах төлбөртэй мэдээллийн жишиг үнэлгээг батлах эрх олгосон заалттай буюу ижил харилцаанд 2 өөр журам мөрдөгдөхөөр байгаа зөрчлийг арилгаж Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд төлбөртэй мэдээллийн жишиг үнэлгээ тогтоох эрхийг холбогдох этгээдэд олгон, Цагдаагийн албаны тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль дахь эрх олгосон заалтыг хүчингүй болгож, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар баталсан жишиг үнэлгээг хэрэглэдэг байх өөрчлөлтийг Цагдаагийн албаны тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд тус тус тусгалаа. Ингэснээр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 30.5 дугаар зүйл мөн нэг мөр хэрэгжих боломжтой болох юм.

Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэгт “Цагдаагийн байгууллага гэмт хэрэг, зөрчлийн улмаас алдагдсан эд зүйлсийн талаарх мэдээллийг агуулсан цахим мэдээллийн сантай байх бөгөөд мэдээллийн санг ажиллуулахтай холбогдсон журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн

Засгийн газрын гишүүн батална.” гэж заасан. Гэтэл Цагдаагийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлд Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд тоо бүртгэл хөтлөх, мэдээллийн сүлжээ, сан үүсгэж ажиллах талаар заасан бөгөөд мөн зүйлд Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 16.2 дахь хэсэгт заасан сан тусгагдаагүй, нөгөө талаас тусад нь журам батлахгүйгээр Цагдаагийн албаны тухай хуулийн 61.6 дахь хэсэгт заасны дагуу батлагдсан “Цагдаагийн байгууллагын мэдээллийн санд мэдээлэл цуглуулах, шалгах, үнэлэн шинжлэх, ашиглах, шилжүүлэх, хүлээн авах, хуваарилах, үр дүнг тооцох, лавлагаа өгөх журам”-аар зохицуулах боломжтой тул Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 16.2 дахь хэсэгт заасан журам батлах эрхийг өөрчлөн, Цагдаагийн албаны тухай хуулийг хэрэглэхээр эшилсэн зохицуулалтыг тусгаж, Цагдаагийн албаны тухай хуульд тусгагдалгүй үлдсэн байсан “гэмт хэрэг, зөрчлийн улмаас алдагдсан эд зүйлийн талаарх мэдээллийн сан” байхаар хуулийн төсөлд тусгав.

#### **12.Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Дотоодын цэргийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4 дэх хэсэгт “Улсын онц чухал объектын хамгаалалтын найдвартай аюулгүй байдлыг хангах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор хамгаалуулагч байгууллагын нэмэлт санхүүжилт авч болох бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батална.” гэж санхүүжилтийг асуудлыг зохицуулах тусдаа журам байхаар тусгасан болно. Гэтэл энэ нь журам гаргах шаардлагагүй бөгөөд хамгаалагч байгууллагатай нэмэлт гэрээ байгуулах замаар зохицуулах боломжтой тул журам батлах эрхийг өөрчилж хуулийн төсөл боловсруулсан болно.

#### **13.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай тухай хуулийн төслийн талаар:**

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.2 дугаар зүйлд зөрчлийн талаарх мэдээллийг иргэдээс төлбөртэй авч болох тухай зохицуулсан бөгөөд мөн зүйлийн 7 дахь хэсэгт “Зөрчлийн талаарх мэдээллийг төлбөртэй авч болно. Мэдээллийг төлбөртэй авах журмыг санхүү, төсвийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.” гэж заасан. Гэвч энэхүү журам одоог хүртэл батлагдаагүй бөгөөд мэдээлэл төлбөртэй авах журам нь Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар зохицуулагдсан, мэдээлэл төлбөртэй авах талаар хэд хэдэн хуульд тухайлбал Цагдаагийн албаны, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль зэрэгт тусгагдсан байгааг анхаарч, Гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээллийг төлбөртэй авах журмыг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд тусгах, мэдээллийн үнэлгээн дээр мөн нэгдсэн нэг жишиг баримтлах зорилгоор Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.2 дугаар зүйлийн 7 дахь хэсгийг өөрчлөн найруулж, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу баталсан жишигийг баримтлахаар хуулийн төсөл боловсрууллаа.

#### **14.Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Монгол Улсын хилийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэгт зааснаар хилчин хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах зорилгоор албаны нохой ашиглаж болох бөгөөд мөн зүйлийн 47.2 дахь хэсгээр албаны нохойг бэлтгэх, ашиглах, хамгаалах журмыг улсын хил хамгаалалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлахаар заасан байна. Өөрөөр хэлбэл албаны нохой ашиглах үндэслэл, журмыг хуульд тодорхой тусгалгүй журмаар зохицуулж ирснийг өөрчилж, албаны нохой хэрэглэх үндэслэл, журмыг хуульд тусган журам батлах эрх олгосон заалтыг өөрчлөн найруулахаар төсөл боловсруулав.

## **15.Гэрээт харуул хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Гэрээт харуул хамгаалалтын тухай хууль нь 2000 онд батлагдсан бөгөөд 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт “Харуул хамгаалалтын үйл ажиллагааг биечлэн гүйцэтгэх боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, мэргэжлийг нь дээшлүүлэх асуудлыг цагдаагийн төв байгууллага хариуцна.” гэж, 10.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 10.1-д заасан сургалтын агуулга, төлөвлөгөө болон сургалтын үйл ажиллагаанд хяналт тавих журмыг хууль зүйн болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.” гэж тус тус заасан. Энэ нь 2023 онд батлагдсан Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн дагуу харуул хамгаалалтын үйл ажиллагааг биечлэн гүйцэтгэх боловсон хүчнийг бэлтгэх сургалт нь мэргэжлийн сургалтад хамаарах сургалтын төрөлд хамаарахаар болсон. Иймд Гэрээт харуул хамгаалалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийг үндэслэн Хууль зүй, дотоод хэргийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын хамтарсан 2001 оны хамтарсан 107/118 дугаар тушаалаар “Гэрээт харуул хамгаалалтын үйл ажиллагааг биечлэн гүйцэтгэх боловсон хүчин бэлтгэх сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө батлах, хяналт тавих журам”-аар зохицуулж байгаа харилцааг хуульд тусган, 10 дугаар зүйлийг Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуульд нийцүүлэн бүхэлд нь өөрчлөн найруулав.

## **16.Хувийн хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн талаар:**

Хувийн хамгаалалтын тухай хуулийн 10 дугаар зүйл хувийн хамгаалалтын сургалт, төлөвлөгөөтэй холбоотой зохицуулалт нь 2023 онд батлагдсан Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн дагуу харуул хамгаалалтын үйл ажиллагааг биечлэн гүйцэтгэх боловсон хүчин бэлтгэх сургалт нь мэргэжлийн сургалтад хамаарах сургалтын төрөлд хамаарахаар болсонд нийцүүлэн холбогдох журмаар зохицуулахаар заасанг хуульд нийцүүлэн өөрчилсөн болно.

## **17.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.11 дэх хэсэг “36.11.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг гадаад улсад авсан иргэн Монгол Улсад уг үйл ажиллагааг эрхлэхтэй холбоотой харилцааг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмаар зохицуулна.”, Нөхөрлөлийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 3, 4 дэх хэсгийг “3.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа хамтран эрхлэх нөхөрлөл энэ хуулийн 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийн хэлбэртэй байна, 4.гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгуулах замаар Монгол Улсад хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой харилцааг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмаар зохицуулна.” тус тус заасныг үндэслэн “Журам батлах тухай” Хууль зүйн сайдын 2013 оны 10 дугаар сарын 14-ны өдрийн А/211 дүгээр тушаалаар “Гадаад улсад хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан иргэн ганцаарчлан болон гадаадын хөрөнгө оруулалттай хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл байгуулан Монгол Улсад хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх журам”-ыг баталсан.

Гэвч Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар “Өмгөөллийн үйлчилгээ” буюу Тавдугаар бүлгийг хүчингүй болгосон бөгөөд ингэснээр мөн хуулийн 36 дугаар зүйл буюу Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2013 оны А/211 дүгээр тушаалыг баталсан эрх зүйн үндэслэл мөн хүчингүй болж хийдэл үүссэн болно. Түүнчлэн энэ асуудлаар Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд тодорхой эрх зүйн үндэслэл байхгүй байх тул гадаад улсын эрх бүхий байгууллагаас хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл

авсан этгээд Монгол Улсад хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа хэрхэн эрхлэх болон гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд байгуулах замаар Монгол Улсад хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах асуудлыг Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд тусгахаар хуулийн төсөл боловсрууллаа. Энэ талаарх зохицуулалтыг Хууль зүйн сайдын 2013 оны 10 дугаар сарын 14-ны өдрийн А/211 дүгээр тушаалаар “Гадаад улсад хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан иргэн ганцаарчлан болон гадаадын хөрөнгө оруулалттай хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл байгуулан Монгол Улсад хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх журам”-д заасныг зарчмын хувьд өөрчлөхгүйгээр тусгахаар хуулийн төсөл боловсрууллаа. Уг хуулийн төслийн хамт Нөхөрлөлийн тухай хуульд өөрчлөлт оруулж, Нөхөрлөлийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг буюу гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгуулах замаар Монгол Улсад хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой харилцааг зохицуулах журам батлах эрх олгосон заалтыг хүчингүй болгохоор хуулийн төслийг боловсруулсан болно.

**18.Нөхөрлөлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд дээр дурдсан агуулгатай нэмэлт, өөрчлөлт орж байгаатай холбоотойгоор Нөхөрлөлийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгуулах замаар Монгол Улсад хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой харилцааг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмаар зохицуулна.” гэж заасны дагуу журам гарах шаардлагагүй буюу энэ харилцаа нь хуулиар зохицуулагдаж байгаа тул уг эрх олгосон заалтыг хүчингүй болгох өөрчлөлтийг хийсэн Нөхөрлөлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

**19.Өмгөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Өмгөөллийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 30.2-т заасан өмгөөлөгч хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу Өмгөөлөгчдийн Холбоонд бүртгүүлснээр Монгол Улсын нутаг дэвсгэрт өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхтэй болох бөгөөд хуульд тусгайлан зохицуулснаас бусад тохиолдолд энэ хуульд заасан ерөнхий нөхцөл, шаардлагын дагуу өмгөөллийн үйл ажиллагаа эрхэлнэ.” гэж тусгав.

**20.Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэгт “Алдуул болон хулгайллагдсан малыг бүртгэх, мэдээлэх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэж заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2014 оны А/190 дугаар тушаалаар уг журмыг баталсан болно. Уг журмаар алдуул болон хулгайллагдсан малын аль байгууллага, хэрхэн бүртгэх, төрийн байгууллагууд мэдээллээ хэрхэн солилцох тухай процедурыг журамласан байх тул журам батлах эрхийг хүчингүй болгож, журмын зохицуулалтыг хуульд тусгахаар төсөл боловсрууллаа.

Түүнчлэн 2017 онд батлагдсан Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуультай зөрчилдсөн болон давхардсан бусад 4 журам батлах эрх олгосон хүчингүй болгохоор хуулийн төсөлд тусгалаа.

**21.Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Мөнгөн зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 16.2 дахь хэсэгт заасан санг ажиллуулах тухай журам одоо хүртэл батлагдаагүй байна. Энэ нь Цагдаагийн

албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлд заасан цагдаагийн байгууллага үйл ажиллагаандaa хөтлөх мэдээллийн сүлжээ, сангийн талаарх зохицуулалттай давхардсан байгаатай холбоотой юм. Цагдаагийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.6 дахь хэсэгт “Энэ хуулийн 61.1.19-д зааснаас бусад мэдээллийн санд мэдээлэл цуглуулах, шалгах, үнэлэн шинжлэх, ашиглах, шилжүүлэх, хүлээн авах, хуваарилах, үр дүнг тооцох, лавлагаа өгөх журмыг дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэж заасны дагуу батлагдсан журмаар холбогдох харилцааг зохицуулж байгаа тул дахин журам гаргах шаардлагагүй юм. Иймд Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 16.2 дахь хэсэгт заасан журам батлах эрх олгосон заалтыг Цагдаагийн албаны тухай хуульд заасан журмаар зохицуулахаар өөрчлөн найруулж, Цагдаагийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлд “гэмт хэрэг, зөрчлийн улмаас алдагдсан эд зүйлсийн сан”-тай байх нэмэлтийг тусгах замаар хууль хоорондын давхардлыг арилгах хуулийн төслийг боловсруулав.

### **22.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэгт “Замын хөдөлгөөн зохицуулах, хянан шалгах зөрчлийн бүртгэлийн оноо тооцох журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэж заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2015 оны А/187 дугаар тушаалаар “Жолоочийн зөрчлийн бүртгэлийн оноо тооцох журам”-ыг баталсан байна. Энэ нь тухайн цаг үедээ зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлж, учрах хохирлыг багасгах, жолооч нарын сахилга хариуцлагыг дээшлүүлж, замын хөдөлгөөнд соёлтой оролцуулах зорилгоор шинээр орж ирсэн зохицуулалт байсан бөгөөд гаргасан зөрчил бүрд оноо хасаж, оноо дууссан тохиолдолд жолоодох эрхийг хүчингүй болгох, тодорхой сургалтад хамрагдсаны дагуу жолоодох эрхээ болон оноог сэргээн авах харилцааг зохицуулсан юм. Энэ нь иргэнд шууд үр дагавар үүсгэж, эрх ашгийг хөндсөн зохицуулалттай бөгөөд нөгөө талаас Зөрчлийн тухай хуульд заасан торгуулийн шийтгэлтэй давхардуулан оногдуулж байгаа нь Зөрчлийн тухай хуулийн үзэл баримтлалтай нийцэхгүй тул зөрчлийн оноо тоолж, давхар шийтгэл оногдуулж байгааг хүчингүй болгохоор хуулийн төсөл боловсрууллаа.

Мөн хуулийн 15 дугаар зүйлээр Жолоодох эрхийн үнэмлэх олгох харилцааг зохицуулсан зохицуулалттай боловч жолоодох эрхийн үнэмлэх олгох болон жолооны багшийн үнэмлэх олгох харилцааг журмаар зохицуулахаар эрх олгосон заалттай. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2015 оны А/189 дүгээр тушаалаар “Жолоодох эрхийн үнэмлэх олгох журам”-ыг баталсан байна. Уг журмаар үндэсний болон олон улсын жолооны үнэмлэх, Венийн конвенцийн гишүүн орнуудаас олгосон, уг конвенцид нийцсэн хүчин төгөлдөр жолоодох эрхийн үнэмлэхийг Монгол Улсын жолоочийн үнэмлэхээр солих, түр зөвшөөрөл олгох зэрэг харилцааг зохицуулсан байна. Эдгээр хуулиар зохицуулагдах ёстой харилцаа байх тул одоо мөрдөгдөж байгаа зохицуулалтыг хуульд тусгах замаар хуулийн төсөл боловсруулсан болно.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлд Тээврийн хэрэгсэл жолоодох эрх дуусгавар болох, эрх сэргээх үндэслэл гэсэн нэртэй боловч Тээврийн хэрэгсэл жолоодох эрх дуусгавар болох, тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг сэргээх харилцааг хуульчлаагүй бөгөөд журмаар зохицуулахаар заасан байна. Энэ нь жолоодох эрхийг хүчингүй болгох, дуусгавар болгох, сэргээх зэргээр хүний эрхийн асуудалд журмыг баримтлан шууд халдаж байгаа хэлбэр юм. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/148 дугаар тушаалаар батлагдсан журмаар жолоодох эрхийг хүчингүй болгох, сэргээх, сургалт явуулах, тэдгээрийн үндэслэл, бүрдүүлэх баримт бичиг, хүсэлт гаргах процедур зэрэг харилцааг

зохицуулж байх тул журмын зохицуулалтыг хуульд тусгахаар төсөл боловсрууллаа.

**23.Төрийн болон албаны нууцын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5-д “Төрийн болон албаны нууцыг задрах, үрэгдэхээс урьдчилан сэргийлсэн, нууц хамгаалалтад бодитой хувь нэмэр оруулсан, хууль бус үйл ажиллагааны талаар мэдээлэл өгсөн буюу бусад хэлбэрээр тагнуул, хууль сахиулах байгууллагад туслалцаа, дэмжлэг үзүүлсэн хуулийн этгээд, иргэнийг урамшуулах журмыг Засгийн газар тогтооно.” гэж эрх олгосны дагуу Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтаар “Төрийн болон албаны нууцыг хамгаалахад туслалцаа, дэмжлэг үзүүлсэн иргэн, хуулийн этгээдийг урамшуулах журам”-ыг баталсан болно. Тус журам төрийн болон албаны нууцыг задрах, үрэгдэхээс урьдчилан сэргийлсэн, нууц хамгаалалтад бодитой хувь нэмэр оруулсан, хууль бус үйл ажиллагааны талаар үнэн зөв мэдээлэл өгсөн буюу бусад хэлбэрээр тагнуул, хууль сахиулах байгууллагад туслалцаа, дэмжлэг үзүүлсэн иргэн, хуулийн этгээдийг урамшуулах хэлбэр, үнэлгээ, санхүүжилт зэрэгтэй холбогдох харилцааг зохицуулсан байх тул хуульд байх нь зүйтэй гэж үзэж хуулийн төслийг боловсрууллаа.

**24.Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Төрийн сүлд, туг, далбааг энгэрийн болон дурсгалын тэмдэг, зурагт хуудас, төрөл бүрийн шошго, бусад зүйл дээр дүрслэх журмыг Засгийн газар тогтооно.” гэж заасны дагуу Засгийн газрын 1994 оны 152 дугаар тогтоолоор “Төрийн сүлд, туг, далбааг энгэрийн болон дурсгалын тэмдэг, зурагт хуудас, төрөл бүрийн шошго, бусад зүйл дээр дүрслэх зөвшөөрөл олгох журам”-ыг баталсан. Уг журмаар иргэд, аж ахуйн нэгж, байгууллага төрийн сүлд, туг, далбааг энгэрийн болон дурсгалын тэмдэг, зурагт хуудас, төрөл бүрийн шошго, бусад зүйл дээр дүрслэлж болох бөгөөд холбогдох хууль тогтоомжид заасан стандарт, шаардлагын дагуу дүрсэлсэн эсэхийг хянаж, зохих зөвшөөрлийг аймаг, нийслэлийн Засаг дарга олгохоор тусгасан байна.

Гэтэл одоог хүртэл Үндсэн хууль, Төрийн бэлгэ тэмдгийн тухай хууль болон стандартад заасан хэлбэр, хэмжээ, харьцааг алдагдуулсан далбаа хэрэглэх тохиолдол гарсаар байна. Үүнээс үзэхэд, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага нь төрийн бэлгэ тэмдгийг энгэрийн болон дурсгалын тэмдэг, зурагт хуудас, төрөл бүрийн шошго, бусад зүйл дээр дүрслэхдээ хуульд заасан стандарт, шаардлагыг хангах, холбогдох байгууллагаас зөвшөөрөл авах журмыг баримталдаггүй, үүнийг хянах механизм хангалтгүй байна. Иймд Төрийн сүлд, туг, далбааг энгэрийн болон дурсгалын тэмдэг, зурагт хуудас, төрөл бүрийн шошго, бусад зүйл дээр дүрслэхдээ иргэн, аж ахуйн нэгж байгууллага хуульд заасан стандарт, шаардлагыг хангах, үүнийг хянан баталгаажуулж, зөвшөөрөл олгох эрх бүхий Аймаг, нийслэлийн Засаг даргын эрх, үргийг хуульчлах зайлшгүй шаардлага үүсээд байх тул Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд төрийн сүлд, туг, далбааг энгэрийн болон дурсгалын тэмдэг, зурагт хуудас, төрөл бүрийн шошго, бусад зүйл дээр дүрслэх зохицуулалтыг тус хуульд өөрчлөлт оруулах замаар тодорхой болгохоор хуулийн төсөл боловсрууллаа.

**25.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Хууль тогтоомжийн тухай хуульд эрх шилжүүлсэн буюу хэм хэмжээний акт батлах эрх олгосон заалтыг хуулийн төсөлд тусгах хүрээ, хязгаар, шаардлага тогтоосон нэг зүйл нэмж тусгахаар хуулийн төсөл боловсруулсан болно. Ийнхүү боловсруулахдаа эрх зүйн бүлүүд болон манай улстай ижил төстэй байж болох

бусад улсуудыг харьцуулсан судалсан онолын болон харьцуулсан судалгааны үр дүнг ашиглан боловсруулсан болно.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэгт заасны дагуу Хүний эрхийн Үндэсний комисстой хамтран хуулийн төслүүдийг “Захиргааны хэм хэмжээний акт ба хүний эрх” сэдвийн хүрээнд эрдэмтэн судлаачид, төрийн захиргааны төв байгууллага, Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа агентлаг байгууллагын хууль, журмын төсөл боловсруулах үүрэг бүхий албан хаагчид, хувийн хэвшил, төрийн бус байгууллага, иргэдийн төлөөллүүдийн дунд 120 гаруй оролцогчийн бүрэлдэхүүнтэйгээр хэлэлцүүлэг зохион байгуулав. Хэлэлцүүлэгт оролцогчид хуулийн төслүүдийн үндсэн зарчмыг 100 хувь дэмжиж, салбар салбар дахь журмаар хүний эрх, эрх чөлөөг зөрчиж байгаа тохиолдол, бодит нөхцөл байдлын талаар хэлэлцүүлэг өрнөлөө

Хуулийн төслүүдийг олон нийтийн саналыг авах зорилгоор Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсэгт заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн яамны [www.mojha.gov.mn](http://www.mojha.gov.mn) цахим хуудаст байршуулав. Түүнчлэн төрийн захиргааны төв, шүүх эрх мэдэл, эрдэм шилжилгээ, судалгааны болон төрийн бус, олон нийтийн зэрэг 38 байгууллагад санал авахаар хүргүүлж, саналыг авч, төслүүдэд боломжтой саналыг тусгаж ажиллаа. Саналын товьёогыг хавсаргав.

-----оОо-----